**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Баянхонгор аймгийн Баянбулаг сумын ОНХС-ийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: БНА-2025/033/НА- СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Баянхонгор хот<br>2025 оны 02 дугаар сарын 19-ний өдөр | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын<br>Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат<br>Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn<br>Аудитын менежер М.Алтантуяа<br>Утас: 70442424 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn<br>Аудитор Д.Цэдэвцэвээн<br>Утас: 89204984 Цахим хаяг: Tsedevtseveend@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# 1.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 1.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **153,373,590.00** | **211,800,824.00** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 153,373,590.00 | 211,800,824.00 |
| **312** | **Банканд байгаа бэлэн мөнгө** | 153,373,590.00 | 211,800,824.00 |
| **3121** | **Төгрөг** | 153,373,590.00 | 211,800,824.00 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 153,373,590.00 | 211,800,824.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **153,373,590.00** | **211,800,824.00** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **153,373,590.00** | **211,800,824.00** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 153,373,590.00 | 211,800,824.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 153,373,590.00 | 211,800,824.00 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 71,857,610.00 | 153,373,590.00 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 81,515,980.00 | 58,427,234.00 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **153,373,590.00** | **211,800,824.00** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **441,743,088.00** | **324,587,800.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **160,122,388.00** | **37,592,500.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 160,122,388.00 | 37,592,500.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 160,122,388.00 | 37,592,500.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 27,402,450.00 | 6,392,500.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 132,719,938.00 | 31,200,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **281,620,700.00** | **286,995,300.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 28,000,000.00 | 30,000,000.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 253,620,700.00 | 256,995,300.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **360,227,108.00** | **266,160,566.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **360,227,108.00** | **266,160,566.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 360,227,108.00 | 266,160,566.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 360,227,108.00 | 266,160,566.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 360,227,108.00 | 266,160,566.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 81,515,980.00 | 58,427,234.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **81,515,980.00** | **58,427,234.00** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **441,743,088.00** | **324,587,800.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **160,122,388.00** | **37,592,500.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 160,122,388.00 | 37,592,500.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 160,122,388.00 | 37,592,500.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 27,402,450.00 | 6,392,500.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 132,719,938.00 | 31,200,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **281,620,700.00** | **286,995,300.00** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 281,620,700.00 | 286,995,300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 28,000,000.00 | 30,000,000.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 253,620,700.00 | 256,995,300.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **441,743,088.00** | **324,587,800.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **360,227,108.00** | **266,160,556.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **360,227,108.00** | **266,160,556.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 360,227,108.00 | 266,160,566.00 |
| 220001 | Барилга байгууламж | 360,227,108.00 | 266,160,566.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **360,227,108.00** | **266,160,566.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 81,515,980.00 | 58,427,234.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 71,857,610.00 | 153,373,590.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 153,373,590.00 | 211,800,824.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | 2023 оны 01-р сарын 01-ээр үлдэгдэл | 00.00 | 00.00 | 71,857,610.00 | 00.00 | 71,857,610.00 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 00.00 | 00.00 | 71,857,610.00 | 00.00 | 71,857,610.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 81,515,980.00 | 00.00 | 81,515,980.00 |
| C08 | 2023 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл | 00.00 | 00.00 | 153,373,590.00 | 00.00 | 153,373,590.00 |
| D01 | 2024 оны 1-р сарын 1-ээрүлдэгдэл | 00.00 | 00.00 | 153,373,590.00 | 00.00 | 153,373,590.00 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 00.00 | 00.00 | 153,373,590.00 | 00.00 | 153,373,590.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 58,427,234.00 | 00.00 | 58,427,234.00 |
| D09 | 2024 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл | 00.00 | 00.00 | 211,800,824.00 | 00.00 | 211,800,824.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Гүйцэтгэл зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 368,276,400.00 | 234,960,700.00 | 133,315,700.00 | 00.64 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **368,276,400.00** | **234,960,700.00** | 133,315,700.00 | 00.64 |
| 220001 | Барилга байгууламж | 368,276,400.00 | 234,960,566.00 | 133,315,834.00 | 00.64 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 368,276,400.00 | 293,387,800.00 | 74,888,600.00 | 00.80 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 272,320,700.00 | 30,000,000.00 | 242,320,700.00 | 00.11 |
| 131008 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | 272,320,700.00 | 00.00 | 272,320,700.00 | 00.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 30,000,000.00 | 286,955,300.00 | -256,955,300.00 | 09.57 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 30,000,000.00 | 30,000,000.00 | 00.00 | 01.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | | 256,955,300.00 | -256,955,300.00 | 00.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 65,955,700.00 | 6,392,500.00 | 59,563,200.00 | 00.10 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 6,392,500.00 | -6,392,500.00 | 00.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 65,955,700.00 | 00.00 | 65,955,700.00 | 00.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **00.00** | **153,373,590.00** | -153,373,590.00 | 00.00 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **00.00** | **211,800,824.00** | -211,800,824.00 | 00.00 |

**Гурав. Аудитын илрүүлэлт:**

Аудитаар нийт 38,173.3 мянган төгрөгийн 4 алдаа зөрчил илрүүлснээс 8,000.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж, 30,173.3 мянган төгрөгийн 2 төлбөр барагдуулах төлбөрийн акт тогтоосон. Үүнд:

**3.1 Зөвлөмж**

**3.1.1** Сумын ОНХС-ын 2023 оны хөрөнгө оруулалтаар цөм сүрэг 400 хонь худалдаж авсан ба Баянбулаг омгийн цөм сүрэг маллах малчинтай гэрээ байгуулан нэг хонь 2250 төгрөг нийт 900.0 мянган төгрөгийн цалин тооцож , гэр бүлийн хүний нийгмийн даатгалыг 74.2 мянган төгрөгөөр сар бүр төлөхөөр гэрээ байгуулсан нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1.7-д заасныг зөрчсөн байна.

Сумын ИТХ-аар тогтоосон эзэмшигч байгууллагад цаашид гарах үр шим, хорогдлыг хариуцуулах зөвлөмж өгөв.

**3.1.2** Сумын ОНХС-ын хөрөнгөөр хэрэгжүүлэхээр сумын ИТХ-аар баталсан Хавар намрын ангилалтын зардлаас малын хээл шалгагч ЭХО аппарат 8,000.0 мянган төгрөгөөр худалдаж авсан. ИТХ-аар баталсан нэршлийн хувьд ангилал гэдэг нь шилмэл мал сүргийг ялган ангилах үйл явц, ЭХО аппарат нь тоног төхөөрөмж гэсэн ойлголтын зөрүүтэй байдал үүсэхээр байна.

Цаашид баталсан төсөл арга хэмжээний нэршил, хэрэгжүүлэх үйл ажиллагааг уялдуулан гүйцэтгэж төлөвлөх зөвлөмж өгөв.

**3.2 Төлбөрийн акт**

**3.2.1** ОНХС-аас 2024 онд Өвс, тэжээл худалдан авахад зарцуулахаар 37,719.9 мянган төгрөгийн төсөл арга хэмжээг баталсан байхад 66,600.0 мянган төгргөөр Өвс тэжээлийг худалдан авч баталсан төсвийг 28,880.1 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” , Монгол Улсын Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 2 дугаар зүйлийн 2.8 дахь заалт “ОНХС-ын хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ бүрийг тухайн шатны ИТХ хэлэлцэн батална”

*__Шийдвэрлэсэн нь:__* Батлагдсан төсвөөс илүү зарцуулсан 28,880.1 мянган төгрөгийг ОНХС-ийн дансанд буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

**3.3 Төлбөрийн акт**

**3.2.2** Сумын ОНХС-ын хөрөнгөөр хэрэгжсэн “Хог булшлах ажил”-ыг "Хатан шижир" ХХК-тай 2024.05.14-ны өдөр 69,550.2 мянган төгрөгөөр байгуулсан ба гэрээд захиалагчийн хяналтын зардал 695.5 мянган төгрөгийг суутган тооцхоор тусгасан байхад суутгаагүй, “Орчны тохижилт”-ын ажлыг "Саннистронг" ХХК-тай 2024.06.03-ны өдөр 41,840.2 мянган төгрөгөөр байгуулсан ба гэрээд захиалагчийн хяналтын зардал 597.7 мянган төгрөгийг суутган тооцохоор тусгасан байхад суутгаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт, "Хог булшлах ажлын гэрээний 8.4 -т "захиалагчийн хяналтын зардал 695.5 мянган төгрөг байна", "Орчны тохижилт"-ын ажлын гэрээний 8.4-т "захиалагчийн хяналтын зардал 597.7 мянган төгрөг байна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь:* Суутгаагүй хяналтын зардал нийт 1,293.0 мянган төгрөгийг ОНХС-ийн дансанд буруутай албан тушаалтнаар төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

**Дөрөв. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

| / мянга төгрөгөөр/ | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс Залруулсан | | Үүнээс Залруулаагүй | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Байхгүй | | | | | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)**

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс Төлбөрийн акт | | Үүнээс Албан шаардлага | | Үүнээс Зөвлөмж | | Үүнээс Хариуцлага тооцох албан шаардлага | | Үүнээс Хуулийн байгууллагад шилжүүлсэн | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Сумын ОНХС-ын 2023 оны хөрөнгө оруулалтаар цөм сүрэг 400 хонь худалдаж авсан ба Баянбулаг омгийн цөм сүрэг маллах малчинтай гэрээ байгуулан нэг хонь 2250 төгрөг нийт 900.0 мянган төгрөгийн цалин тооцож , гэр бүлийн хүний нийгмийн даатгалыг 74.2 мянган төгрөгөөр сар бүр төлөхөөр гэрээ байгуулсан нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1.7-д заасныг зөрчсөн байна. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| Сумын ОНХС-ын хөрөнгөөр хэрэгжүүлэхээр сумын ИТХ-аар баталсан Хавар намрын ангилалтын зардлаас малын хээл шалгагч ЭХО аппарат 8,000.0 мянган төгрөгөөр худалдаж авсан. ИТХ-аар баталсан нэршлийн хувьд ангилал гэдэг нь шилмэл | 1 | 8,000.0 | | | | | 1 | 8,000.0 | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| мал сүргийг ялган ангилах үйл явц, ЭХО аппарат нь тоног төхөөрөмж гэсэн ойлголтын зөрүүтэй байдал үүсэхээр байна. | | | | | | | | | | | | |
| ОНХС-аас 2024 онд Өвс, тэжээл худалдан авахад зарцуулахаар 37,719.9 мянган төгрөгийн төсөл арга хэмжээг баталсан байхад 66,600.0 мянган төгргөөр Өвс тэжээлийг худалдан авч баталсан төсвийг 28,880.1 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна. | 1 | 28,880.1 | 1 | 28,880.1 | | | | | | | | |
| Сумын ОНХС-ын хөрөнгөөр хэрэгжсэн “Хог булшлах ажил”-ыг "Хатан шижир" ХХК-тай 2024.05.14-ны өдөр 69,550.2 мянган төгрөгөөр байгуулсан ба гэрээд захиалагчийн хяналтын зардал 695.5 мянган төгрөгийг суутган тооцхоор тусгасан байхад суутгаагүй, “Орчны тохижилт”-ын ажлыг "Саннистронг" ХХК-тай 2024.06.03-ны өдөр 41,840.2 мянган төгрөгөөр байгуулсан ба гэрээд захиалагчийн хяналтын зардал 597.7 мянган төгрөгийг суутган тооцохоор тусгасан байхад суутгаагүй байна. | 1 | 1,293.0 | 1 | 1,293.0 | | | | | | | | |
| Дүн | 1 | 38,173.3 | 1 | 30,173.3 | | | 1 | 8,000.0 | | | | |

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | | | + | | | | | |
| 2 | Төсөл, хөтөлбөр | | | | | | | | |
| 3 | ЗГТС | | | | | | | | |
| 4 | ТТЗ | | | | | | | | |
| 5 | ТЕЗ | | | | | | | | |
| | **НИЙТ** | | | + | | | | | |

---oOo---

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2025 оны 02 сарын 25 өдөр Дугаар 73 Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Баянбулаг сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сумын Орон нутгийн хөгжлийн сангаас 2024 онд Өвс, тэжээл худалдан авахад зарцуулахаар 37,719,900 (Гучин долоон сая долоон зуун арван есөн мянга есөн зуун) төгрөг баталсан байхад 66,600,000 (Жаран зургаан сая зургаан зуун мянган) төгрөгийн санхүүжилт олгож баталсан төсвөөс 28,880,100 (Хорин найман сая найман зуун наян мянга нэг зуун) төгрөг илүү зарцуулсан байна.

Энэ нь Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” , Монгол Улсын Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 2 дугаар зүйлийн 2.8 дахь заалт “ОНХС-ын хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ бүрийг тухайн шатны ИТХ хэлэлцэн батална” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

5050141

1. Батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулсан 28,880,100 (Хорин найман сая найман зуун наян мянга нэг зуун) төгрөгийг сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 100031652400 тоот дансанд төвлөрүүлэх[1]

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, нотлох баримтыг 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Баянбулаг сумын Засаг дарга Д.Батболд, нягтлан бодогч Ц.Алтангэрэл нарт даалгав[2].

**ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН[3]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

АУДИТОР: Д.ЦЭДЭВЦЭВЭЭН

6417143544
ВЮА0067 0007423

---

[1] Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

[2] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

[3] Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2025 оны 02 сарын 05 өдөр Дугаар 74/ Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Баянбулаг сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сумын ОНХС-ын санхүүжилтээр хэрэгжсэн “Хог булшлах ажил”-ыг "Хатан шижир" ХХК-тай 69,550,234 (Жаран есөн сая таван зуун тавин мянга хоёр зуун гучин дөрвөн) төгрөгөөр байгуулсан гэрээд захиалагчийн хяналтын зардал 695,502 (Зургаан зуун ерэн таван мянга таван зуун хоёр) төгрөгийг суутган тооцохоор тусгасан, “Орчны тохижилт”-ын ажлыг "Саннистронг" ХХК-тай 41,840,260 (Дөчин нэгэн сая найман зуун дөчин мянга хоёр зуун жаран) төгрөгөөр байгуулсан гэрээд захиалагчийн хяналтын зардал 597,718 (Таван зуун ерэн долоон мянга долоон зуун арван найман) төгрөгийг суутган тооцохоор тусгасан байхад Захиалагчийн хяналтын зардал нийт 1,293,220 (Нэг сая хоёр зуун ерэн гурван мянга хоёр зуун хорин) төгрөгийг суутгаагүй гүйцэтгэгч байгууллага руу шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, "Хог булшлах ажлын гэрээний 8.4 -т "захиалагчийн хяналтын зардал 695,502 төгрөг байна", "Орчны тохижилт"-ын ажлын гэрээний 8.4-т "захиалагчийн хяналтын зардал 597,718 төгрөг байна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага

5050144

өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Гэрээний дагуу суутган тооцоогүй нийт 1,293,220 (Нэг сая хоёр зуун ерэн гурван мянга хоёр зуун хорин) төгрөгийн захиалагчийн хяналтын зардлыг төсвийн захирагч, нягтлан бодогчоор төлүүлж сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 100031652400 тоот дансанд төвлөрүүлэх[1]

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, нотлох баримтыг 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Баянбулаг сумын Засаг дарга Д.Батболд, нягтлан бодогч Ц.Алтангэрэл нарт даалгав[2].

**ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН[3]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

АУДИТОР: Д.ЦЭДЭВЦЭВЭЭН

[1] Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

[2] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 “Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана.”

[3] Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно